

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/143/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 90900910

Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 99057478

Цахим хаяг:

Аудитор:

Г.Намчинсүрэн

Утас: 91995689

Цахим хаяг: Namchinsuren999@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	4
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	10
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал.....	10
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..	10
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	Error! Bookmark not defined.
2.11.	Шилэн дансны мэдээлэл	11
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	11
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	11
3	Менежментийн захидал	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	14

1 Аудитын гэрчилгээ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг дарга Н.Батжаргал-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 07-ноос 2020 оны 02 дугаар сарын 14-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 14-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газрын Г.Намчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймаг Улсын төсвийн Халамжийн сан 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/50 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх;
- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал,

нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;

- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Улсын төсвийн халамжийн сангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулахгүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Булган аймгийн улсын төсвийн халамжийн сан санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “VERITECH” программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 8 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1785828.9 мянган төгрөгөөс тооцон 35716.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 170112.2 мянган төгрөгөөр тооцсон нь байгууллагын нийт болон цэвэр хөрөнгөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг байдлын түвшин хэт өндөр гарч байгаа, нийт орлогын хувьд дээшээ шууд төвлөрүүлдэг тул нийт зардлын 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Улсын төсвийн халамжийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 4057.1 мянган төгрөгөөр буюу 100 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		4057167.55	4057167.55
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал			

Үндсэн хөрөнгө			
Нийт хөрөнгө		4057167.55	4057167.55
Өр төлбөр		6350930.00	6350930.00
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/		-2293762.45	-2293762.45
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн		4057167.55	4057167.55

Өр төлбөр дансны үлдэгдэл 6350.9 мянган өссөн нь орон нутгийн халамжийн сангийн авлагын 550.0 төгрөгийг улсын халамжийн сангийн дансанд төвлөрүүлсэн, амьжиргаа дэмжих зөвлөлийн урамшууллын ХХОАТ-ын 305.8, байгууллагад өгөх хүнсний эрхийн бичгийн үлдэгдэл санхүүжилт 1800.0, хувь хүний тэтгэвэр тэтгэмжийн банк дахь үлдэгдлээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэлд 2019 онд үүссэн 635.0 мянган төгрөг нийт өр төлбөрийн 100 хувийг эзэлж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй болно.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь тайлант онд 96638.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 102170.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйл ажиллагааны орлого	966380.0	102170.8	5532.8	105.7
Нийт дүн	966380.0	102170.8	5532.8	105.7

Тайлант онд халамжийн сангийн зардалд 8489181.2 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 8489181.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Халамжийн сангийн зарцуулалт гүйцэтгэлээр 8405642.2 мянган төгрөгийг зарцуулж төсвийн гүйцэтгэл 99.01 хувьтай байгаа нь төсвийг оновчтой төлөвлөж, зарцуулсантай холбоотой байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтөйд тооцож, 4 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	2	6,371.30	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
Дүн		2	6,371.30	

2.10.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй болно.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.12. Шилэн дансны мэдээлэл

Булган аймаг Улсын төсвийн Халамжийн сан Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Авлага, өглөг данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 6371.3 мянган төгрөгийн өглөгийг шинээр үүсгэсэн байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй нь НББ-ийн тухай хуулийн 20.2.6 заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй, санхүүгийн тайлангийн аудитын эрх ба үүрэг, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, холбогдох дүрэм журам зөрчигдөх

1.3. Өгсөн зөвлөмж:

Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Зардал данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлэх үйлчилгээний зарцуулалтыг түүвэрлэн үзэхэд анхан шатны баримтын бүрдлийг сумдын мэргэжилтнүүд нэгэн жигд бүрдүүлдэггүй, архивын нэгж болгосон баримт эмх цэгцгүй, нийгмийн ажилтан дээрх тушаалын дөрөв дүгээр хавсралт, 5 дугаар хавсралт, хүнсний дэлгүүр гэрээний хавсралт "Хүнсний

бүтээгдэхүүн худалдан авсан тухай бүртгэл, “Тооцоо нийлсэн акт” –ыг тухай бүр тогтмол хөтлөхгүй байгаа нь Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалтай бүрэн нийцэхгүй байна.

2.2. Эрсдэл:

Ашиг сонирхлын зөрчил үүсэх, холбогдох дүрэм, журам зөрчигдөх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2014 оны А/32 дугаар тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 05 дугаар 05-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	0.00	4057167.55
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	4057167.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.00	4057167.55
3121	Төгрөг	0.00	4057167.55
31213	Арилжааны банк дахь харилцах	0.00	4057167.55
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	0.00	4057167.55
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	6350930.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	6350930.00
413	Өглөг	0.00	6350930.00
4136	Бусад өглөг	0.00	6350930.00
41361	Байгууллагад төлөх өглөг		2715400.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг		3635530.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	0.00	-2293762.45
51	Засгийн газрын хувь оролцоо	0.00	-2293762.45
512	Хуримтлагдсан үр дүн	0.00	-2293762.45
51220	Тайлант үеийн үр дүн		-2293762.45
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	0.00	4057167.55

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,117,896,890.49	8,503,317,978.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,796,890.49	14,136,708.84
120	Нийтлэг татварын бус орлого	4,796,890.49	14,136,708.84
120002	Хүүгийн орлого	4,795,890.49	14,136,708.84
120009	Бусад орлого	1,000.00	
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,113,100,000.00	8,489,181,270.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,113,100,000.00	8,489,181,270.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,113,100,000.00	8,489,181,270.00

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,117,896,890.49	8,505,611,741.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,117,896,890.49	8,505,611,741.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,117,896,890.49	8,505,611,741.29
2104	Хангамж, бараа материалын зардал	1,770,125,200.00	1,719,875,640.00
210401	Цалинтай ээж	1,694,925,200.00	1,607,857,850.00
210402	Өрх толгойлсон	75,200,000.00	112,017,790.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,347,771,690.49	6,785,736,101.29
210801	Жирэмсэн эх	-	214,337,370.00
210802	Хүнс тэжээл	-	708,671,500.00
210803	Алдарт эхийн одон	726,860,000.00	736,000,000.00
210804	ахмад дайчид алдар цолтон	60,756,510.00	61,482,190.00
210805	төвлөрүүлэх	80,475,180.49	100,888,384.29
210806	амжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал		19,845,400.00
210807	банкны шимтгэл		3,163,050.00
210808	тэтгэвэр		2,040,186,960.00
210809	тэтгэмж		1,229,806,760.00
210810	Амжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж		633,034,920.00
210811	Ахмад настны хөнгөлөлт		441,863,500.00
210812	ХБИ		99,356,067.00
210813	насны хишиг	479,680,000.00	497,100,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	(2,293,762.45)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-	(2,293,762.45)

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	3119006890.49	8510587808.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5906890.49	21406538.84
120	Нийтлэг татварын бус орлого	5906890.49	21406538.84
120002	Хүүгийн орлого	4795890.49	14136708.84

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

120007	буцаасан орлого	1110000.00	7269830.00
120009	Бусад орлого	1000.00	0.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3113100000.00	8489181270.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3113100000.00	8489181270.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3113100000.00	8489181270.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3119006890.49	8506530641.29
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3119006890.49	8506530641.29
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3119006890.49	8506530641.29
2104	Хангамж, бараа материалын зардал	2311471710.00	2911006670.00
210401	ахмад дайчин алдар цолтон	60756510.00	61482190.00
210403	Амжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж		633180120.00
210404	насны хишиг	480310000.00	497100000.00
210406	Цалинтай ээж	1695125200.00	1607146570.00
210407	өрх толгойлсон	75280000.00	112097790.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	807535180.49	5595523971.29
210801	жирэмсэн эх	0.00	216904760.00
210802	хүнс тэжээл	0.00	706807500.00
210804	төвлөрүүлэх	80475180.49	100888384.29
210806	амжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал	0.00	19560000.00
210807	банкны шимтгэл		3163050.00
210808	тэтгэвэр	0.00	2041932670.00
210809	тэтгэмж	0.00	1229824040.00
210816	Ахмад настны хөнгөлөлт	0.00	441587500.00
210817	ХБИ	0.00	99356067.00
210818	алдарт эхийн одон	727060000.00	735500000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	0.00	4057167.55
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	0.00	4057167.55
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	4057167.55

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл					0.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт					0.00

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт					0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
C07	Тайлант үеийн үр дүн			0.00		0.00
C08	2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00	0.00
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт					0.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт					0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз					0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			-2,293,762.45		-2,293,762.45
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	-2,293,762.45	0.00	-2,293,762.45

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3177474200.00	3037421710.00	8489181270.00	8405642257.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2276674200.00	2174605200.00	6634080270.00	6572850017.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	479550000.00	479680000.00	523330000.00	519823050.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	479550000.00	479680000.00	523330000.00	519823050.00
210801	насны хишиг	479550000.00	479680000.00	499600000.00	497100000.00
210802	амжиргааг дэмжих зөвлөлийн урамшуулал			19560000.00	19560000.00
210803	банкны шимтгэл			4170000.00	3163050.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1797124200.00	1694925200.00	6110750270.00	6053026967.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1797124200.00	1694925200.00	6110750270.00	6053026967.00
213204	Халамжийн тэтгэвэр		0.00	2042037940.00	2041932670.00
213205	Халамжийн тэтгэмж			1237475330.00	1229824040.00
213206	Амжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж			638700000.00	633180120.00
213207	Ахмад настны хөнгөлөлт	27000000.00		441923000.00	441587500.00

Улсын төсвийн халамжийн сангийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213208	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн			114158000.00	99356067.00
213209	Цалинтай ээж	1770124200.00	1694925200.00	1636456000.00	1607146570.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	900800000.0	862816510.0	1855101000.0	1832792240.0
2200	Дотоод эх үүсвэрээр	900800000.0	862816510.0	1855101000.0	1832792240.0
220001	өрх толгойлсон	75800000.00	75200000.00	118559000.00	112097790.00
221001	жирэмсэн эх		0.00	223058000.00	216904760.00
222001	хүнс тэжээл		0.00	712884000.00	706807500.00
223001	алдарт эхийн одон	740000000.00	726860000.00	739000000.00	735500000.00
224001	алдар цолтон	85000000.00	60756510.00	61600000.00	61482190.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				4057167.55